

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.05.15 № 03/3874

танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ТБ/20240102115 дугаартай “Цахилгаан үүсгүүр нийлүүлэх” тендер шалгаруулалтад оролцсон “СОББИ” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох материалд үндэслэн гомдлын хүрээнд хянан үзлээ.

“СОББИ” ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Нийслэл түгээх сүлжээ” ХХК-ийн тендерийн материалтай танилцахад ижил төстэй бараа нийлүүлснийг нотлох баримт шаардлага хангахгүй, нийлүүлэх барааны паспортын хуулбар ирүүлээгүй, наалт шошго нь үсгийн алдаатай байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Нийслэл түгээх сүлжээ” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. “Нийслэл түгээх сүлжээ” ХХК-ийн тендерт ирүүлсэн 2023 онд “Асралт мед” ХХК-тай байгуулсан НТС-АГГ-52/23 дугаартай 280 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ, захиалагчийн тодорхойлолт нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д заасан “Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: Шаардана 2022, 2023 онуудын гэрээний нийлбэр дүн нь батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй Цахилгаан үүсгүүр нийлүүлж, хүлээлгэн өгсөн мэдээлэл ирүүлнэ. Үүнд: - Гэрээний хуулбар; - Бараа хүлээлцсэн акт /гэрээ дүгнэсэн акт/ эсхүл захиалагчийн тодорхойлолт” гэсэн шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2. “Нийслэл түгээх сүлжээ” ХХК-ийн тендерт СЕ-910-03-140423 дугаартай Тохирлын баримт бичиг, 39322Q1281R1M дугаартай Чанарын удирдлагын гэрчилгээ ирүүлсэн нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1-д заасан “...Нийлүүлэх барааны техникийн паспортын эх хувиас хийсэн хуулбар ирүүлнэ.” гэсэн шаардлагад нийцэх эсэхэд үнэлгээ хийгээгүй байх тул нягталж үзэх нь зүйтэй байна.

3. Гомдолд “Нийслэл түгээх сүлжээ” ХХК-ийн тендерт ирүүлсэн нийлүүлэх барааны зураг дээр “Бензиновый генератор” гэж алдаатай бичиг байгаа нь санал

болгосон барааны чанарт эргэлзүүлж байгаа талаар дурдсан байх тул барааны танилцуулга, фото зураг нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1-д "...Нийлүүлэх барааны дэлгэрэнгүй танилцуулга, зураг ирүүлнэ." гэж заасан шаардлагад нийцэх эсэхийг нягталж үзэх нь зүйтэй байна.


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 17/2364 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "СОББИ" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ